



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Төвийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/11 дүгээр тушаал, Төвийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.5 дахь заалт, Удирдлагын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвд мөрдөгдөх төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийн цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын дагуу албан хаагчдын цалин хөлсийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон олгохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны Ахлах нягтлан бодогч /М.Жавхлан/-д зөвшөөрсүгэй.

3. Албан хаагчдад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан нэмэгдэл, бусад нэмэгдлийг тооцохдоо Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтлахыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны цалингийн нягтлан бодогч /Д.Байгалмаа, Н.Уранцэцэг/, Ахлах нягтлан бодогч /М.Жавхлан/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Э.Бямбасүрэн/, Хүний нөөцийн албаны дарга /Б.Мөнхшүр/ нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

1606060041

Захирлын 2026 оны ...-р сарын ...-ны
өдрийн тоот тушаалын хавсралт

ЭХЭМҮТ-ИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ /сард төгрөгөөр/

Ангилал Зэрэглэл	ТҮЭМ	ТҮМ	ТҮ
1	1.515.800	1.378.000	1.240.200
2	1.667.900	1.515.800	1.303.900
3	1.751.100	1.667.900	1.367.600
4	1.838.200	1.751.100	1.436.500
5	1.929.200	1.838.200	1.508.000
6	2.026.700	1.929.200	1.658.800
7	2.128.100	2.026.700	1.742.000
8	2.233.400		1.842.100
9	2.346.500		2.025.400